

ХҮҮХДЭД ЭМИЙН ТУНГ ТООЦОХ НЬ

А.Алтанцэцэг (ЭЗУ-ы магистр), “ЭЗШУИС”

Бие махбодид жин, эзлэхүүн, үйлдлийн нэгж (Ед)-ээр хэмжиж оруулах эмийн бодисын хэмжээг **эмийн тун** гэнэ.

Эмийн тун нь:

- ✓ Хэрэглэж байгаа арга зам
- ✓ Өвчтөний нас, жин
- ✓ Газар зүйн онцлог
- ✓ Цаг улирлын байдал
- ✓ Хоол хүнсний хэрэглээ
- ✓ Амьдралын нөхцөл
- ✓ Элэгний хоргүйжүүлэх үйлчлэл
- ✓ Бөөрний ялгаруулах, цэвэршүүлэх ажиллагаа
- ✓ Өвчтөний хүнд, хөнгөний зэрэг
- ✓ Хувь хүний биемахбодийн онцлог зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай.

Хүүхдэд хэрэглэх эмийн тунг дотор нь:

- Эмчилгээний тун
- Хордуулах тун
- Үхлийн тун гэж ангилна.

Эмчилгээний тун гэдэг нь: хүүхдэд эмчилгээний үр нөлөө үзүүлж чадах эмийн бодисын хэмжээг хэлнэ.

Хордуулах тун гэдэг нь эмчилгээний дээд тунгаас хэтэрсэн хэмжээг хэлнэ.

Үхлийн тун гэдэг нь хордуулах тунгаас хэтэрсэн эмийн бодисын хэмжээг хэлнэ.

Эмийн эмчилгээний тунг дотор нь:

- Эмчилгээний бага тун
- Эмчилгээний тун
- Эмчилгээний дээд тун гэж ангилдаг.

Эмийн эмчилгээний үйлчлэл үзүүлж байгаа хамгийн доод хэмжээг **бага тун** гэнэ.

Үүнээс бага тунгаар хэрэглэхэд үйлчлэл үзүүлэхгүй.

Эмчилгээний дунд буюу стандарт тун нь эмийг тогтмол хэрэглэх тун бөгөөд үйлчлэлийн чадлаар эмчилгээний үр нөлөө үзүүлэх **дундаж тун** хэмжээ юм.

Дундаж тун нь эмчилгээний дээд тунгийн $\frac{1}{2}$ - $\frac{1}{3}$ - тэй ерөнхийдөө тохирно.

Эмчилгээний үйлчлэл үзүүлэх хамгийн их хэмжээг **дээд тун** гэдэг. Үүнээс ялимгүй нэмэгдэхэд хордлого үзүүлнэ. Түүнчлэн хүүхдэд хэрэглэх эмчилгээний тунг

- Нэг удаагийн тун
- Хоногийн тун
- Курс (мөчлөг) эмчилгээний тун гэж хуваана.

Эм нэг удаа хэрэглэх хэмжээг **нэг удаагийн тун** гэнэ.

Нэг хоногт хэрэглэх нийт эмийн хэмжээг **хоногийн тун** гэнэ. Хоногийн тун эмчилгээний хэд хэдэн тун буюу 2-4-6 тунгаас бүрдэнэ. Хүүхдэд хэрэглэх хүчтэй болон хортой үйлчилгээтэй ихэнх эмэнд эмчилгээний нэг удаагийн болон хоногийн тунг эмч зааж өгнө. Энэ заалтыг дураар өөрчилбөл хордуулах, гаж нөлөө гарах улмаар үхүүлэх тун ч болж болзошгүй.

Өвчтэй хүүхдийг эдгэртэл хэрэглэх эмийн нийт хэмжээг курс (мөчлөг) **эмчилгээний тун** гэнэ. Тухайлбал: хүүхдийн цагаан хорхойн өвчин, рахит, ходоод гэдэс, зүрх судас, бөөрний өвчний үед курс эмчилгээ хийнэ.

Эмчилгээний тунгаас бага, биед үйлчлэл үзүүлэх хэмжээг **босгоны тун** гэнэ. Босгоны тунгаас хордлого үзүүлэх хүртэл зайг **эмчилгээний хүрээ** гэнэ. Эмчилгээний хүрээ өргөн бол хордлого бага, эмчилгээний хүрээ нарийн бол хордлого их үзүүлэх эм гэж тооцно.

Эмчилгээний хүрээ нь:

- ✓ Тухайн эмийн биед хуримтлагдах
- ✓ Биед явагдах солилцооны хувирал
- ✓ Биеэс ялгаран гарах хугацаа
- ✓ Эмийн химийн шинж чанар зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

Түүнчлэн эмчилгээнд:

- Цохилтын тун
- Тогтоох тун
- Урьдчилан сэргийлэх тунг зөв хэрэглэх нь чухал.

Цохилтын тун: Цохилтын тунг эмчилгээний эхний хоногуудад хэрэглэнэ. Цохилтын тун нь эмчилгээний тунгаас хоёр дахин их байна. Цохилтын тунг өвчний эхний үед цусан дахь эмийн хэмжээг өндөр байлгаж, богино хугацаанд үр дүнд хүргэдэг.

Тогтоох тун: Энэ тун нь эмчилгээний үр дүнг хадгалж, үйлчилгээг удаан байлгадаг. Тогтоох тун нь эмчилгээний болон ханах тунгаас 2-5 дахин бага байна.

Урьдчилан сэргийлэх тун: Өвчин үүсэхээс сэргийлдэг. Витамин дутагдал, рахит, мөөгөнцөртөх болон бусад өвчнөөс сэргийлж хэрэглэнэ. Хүүхдэд эмийн тунг тооцох гол гурван арга байдаг. Үүнд:

- ✓ Эмийн тунг кг жинд тооцно.
- ✓ Эмийн тунг нас тутамд тооцно.
- ✓ Эмийн тунг биеийн гадаргууд тооцно.

1 нас хүртэл хүүхэд шүүдэст эмзэгшил (жин дутуу), рахит, цус багадалт зэрэг суурь өвчин элбэг байдаг учир **кг жинд** тооцно.

1 наснаас дээш настай хүүхдэд нас, биеийн өсөлт хөгжилт, онцлог байдлаар бие биенээс их ялгарахгүй тул **нас тутамд** тунг тооцож болно.

Хүүхдийн элэг, бөөр, дотоод шүүрэл, сүрьеэ, хавдар болон бусад ужиг, архаг халдварын үед биеийн гадаргуугийн талбайд эмийг тооцох нь илүү нарийвчилсан арга байдаг.

5 настай хүүхдийн байх ёстой жин, биеийн гадаргууг томъёо ашиглан тооцвол:

$$B_{ж}=10+2 \cdot H$$

Бж - 5 настай хүүхдийн биеийн жин, кг

10 – Нэг настай хүүхдийн биеийн жин, кг

2 – Ой өнгөрсөн хүүхэд жил тутам 2 кг нэмэгдэх буюу тогтмол тоо

H – Хүүхдийн нас, жилээр

1 нас өнгөрсөн хүүхдийн биеийн гадаргуу олохдоо насыг 0,06 гэсэн тогтмол тоогоор үржүүлж, нэг настай хүүхдийн биеийн гадаргуу (0,43м²) дээр нэмж тооцдог.

$$S(m^2)=0,43+0,06 \cdot H$$

S(м²) – 5 настай хүүхдийн биеийн гадаргуу, м²

0,43 – Нэг настай хүүхдийн биеийн гадаргуу, м²

0,06 – Тогтмол тоо

H – Хүүхдийн нас, жилээр

Хүүхдэд өгөх шингэн эмийг халбагаар болон дуслаар тунлах нь хамгийн энгийн тохиромжтой арга юм.

Халбаганы нэршил	Хэмжээ, мл	Жор бичих хэмжээ, мл	Хэрэглэх нас
Цайны	4,0-5,0	100-150	0-3
Зуушны (дундын)	8,0-10,0	150-180	4-11
Хоолны	15,0-20,0	0-200	12 дээш

Эмийн тунг мл-т орох дуслын тоогоор тооцно.

Шингэн	1 мл-т орох дуслын тоо
Усан уусмал	20-25
Тосон уусмал	30-35
Спиртэн уусмал	40-50
Эфир	60-80

Хүүхдэд эмийн тунг тооцох олон арга байдаг.

1. Хүүхдийн насны үе шат, жин, биеийн гадаргуу, бүтэц, үйлийн онцлог харгалзан эмийг “тунлах хүчээр” тооцох арга:

Нас	Тунлах хэмжээ
0-1 нас	1,8
1-6 нас	1,6
6-10 нас	1,4
10-14 нас	1,4
14 дээш нас	1,2

2. Биеийн жинд харьцуулан эмийн тунг тооцох арга:

$$D_x = \frac{J(\text{кг})}{70} * D_t$$

D_x – Хүүхдийн тун

D_t - Хүүхдийн жин, кг

Ж- Том хүний дундаж тун

70- Тогтмол тоо

3. Хүүхдийн насанд тохируулан эмийн тунг тооцох арга:

$$D_x = \frac{H}{H+12} * D_t$$

4. Хүүхдийн биеийн гадаргууд эмийн тунг тооцох арга:

$$D_x = \frac{S(\text{м}^2)}{1.73} * D_t$$

D_x – Хүүхдийн тун

$S(\text{м}^2)$ - Хүүхдийн биеийн гадаргуу, м^2

D_t - Насанд хүрэгчдийн дундаж тун

1.73- Насанд хүрэгчдийн биеийн гадаргуу (м^2)

5. Насанд хүрэгчдийн тунгийн харьцуулсан хувиар тунг тооцох арга:

7-10 настай хүүхдэд насанд хүрэгчдийн тунгийн 40%-ийг хэрэглэнэ гэж тооцно. 10-аас дээш 2 нас тутамд 10% нэмж, 7-оос доош 2 нас тутамд 10% бууруулж тунг тооцно.

6. Тайвшруулах, нойрсуулах, унтуулгын эмийн тунг тооцох:

$$D_x = \frac{D_t (4 \cdot H) + 20}{100}$$

D_x – Хүүхдийн тун

D_t – Насанд хүрэгчдийн тун

H - Хүүхдийн нас, жилээр

100- Тогтмол тоо

20 – Тогтмол тоо

4 – Тогтмол тоо

7. Нярайд тунг тооцох арга:

$$D_{nx} = (<1 \text{ нас}) \underline{H} \cdot D_t$$

150

D_{nx} - Дутуу нярай хүүхдийн тун

H –Хүүхдийн нас, сараар

D_t – Насанд хүрэгчдийн дундаж тун

150 – Тогтмол тоо

8. Эмийн хэрэглэх аргаас хамаарч тун тооцох арга

Уух тунг нэг бүтэн тун гэж тооцвол:

- Арьсан дор $\frac{1}{2}$
- Булчинд $\frac{1}{3}$
- Судсанд $\frac{1}{4}$
- Шулуун гэдсэнд тухайн тунг 2 дахин ихэсгэж хэрэглэнэ.

